АРВАЙХЭЭР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ 2025 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ: АЖ АХУЙ НЭГЖ, ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙГООР ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЗАМААР ЭРҮҮЛ ЦЭВЭР ОРЧИН БҮРДҮҮЛНЭ.** | | | | | | | |
| 1.1 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг 10, 11, 13 дугаар багаас эхлүүлж, тус багуудийн айл өрхийн 30 хувьд хүргэнэ. | - | Тус 3 багийн нийт өрхийн хувиар | 5 хувь | 30 хувь | Арвайхээр сумын 10,11,13 дугаар баг нийт 2900 айл өрхтэй, нийт айл өрхийн 10 хувь нь буюу 291 өрх хогоо ангилан ялгаж хэвшсэн нь өмнөх оноос 5 хувиар өссөн байна. 13 дугаар баг нийтийн зориулалттай 75 орон сууцтай, үүний 5 орон сууцны 170 өрх хогоо ангилан ялгаж, дадал болгосон. Тус багуудын хог тээврийн үйлчилгээнд явдаг машин нь хуванцар, лааз ангилан хийдэг зориулалтын савтай тул айл өрх ангилан ялгаж хэвшиж байна. | 34 хувь |
| 1.2 | Хог хаягдлыг багасгах зорилгоор хоёрдогч түүхий эд авах цэгийг ашиглалтанд оруулж, ангилан ялгах, боловсруулах ажлыг эрчимжүүлэх. | - | Боловсруулсан хог хаягдлын тн-ын хэмжээгээр | 20 тн | 30тн | Энэ оны 10 сарын байдлаар нийт 59302тн хог хаягдлыг хогийн цэгт зөөвөрлөж, хог хаягдлын 1.3 хувийг ангилан ялгасан. Мөн хогийн цэгийн аж ахуйн хашаандаа хуванцар хайлуулан 100 диаметртэй, 2 метрийн өндөртэй 580 ширхэг хашааны шон хийж, аймгийн БОАЖГазар, Хужирт суманд нийлүүлсэн.<br>Ангилан ялгалтын хувьд: зөөлөн хуванцар 2тн, лааз 1,3тн, төмөр 13,3тн, ундааны сав 3,1тн, гялгар уут 618кг, хайлш 107кг, зэс 7,8кг ангилан ялгасан. Үүнээс хуванцар болон лааз, төмрийг “Цэмцгэр” төвд нийлүүлж, нийт 8,250,000 төгрөгийн орлого олсон. | 80 хувь |
| 1.3 | Түгээ овооны хогийн цэгийн тэлэлтийг багасгах, түрж тэгшлэх ажлыг тогтмол зохион байгуулж, хог шатах эрсдэлээс урьдчилан сэргийлэх. | 169 сая | Багасгасан талбайн хэмээ (га) | 3 га | 2.5 | Хогийн цэгийн тэлэлтийг багасгах зорилгоор хог хаягдлыг дарж булах, хөрсжүүлэх ажил тогтмол хийгдэж байна. 2024 онд 4 га газрын 1,2 га,г хөрсжүүлж, улиас хайлаас тарьсан. Энэ оны хувьд шинээр 1га газарт нөхөн сэргээлт хийн хашааг тэлж улмаар 3.8га болсон байна. Үүний 2.2 га газарт 500 хайлаас, улиас тарьсан.<br>Энэ онд 3 удаа хог шатсаныг унтраасан. Цогтой үнс ачигдан хогийн цэгт шаталт үүссэн тохиолдолд | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Арвайхээр Тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГазраас яаралтай арга хэмжээ авч шороо тээвэрлэн зөөж, унтраах ажлыг хийсэн. | |
| 1.4 | Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний техник, хэрэгсэлд засвар үйлчилгээ, шинэчлэл хийхэд зөвлөмж өгч, холбон зуучлах. | - | Механикжсан техникээр цэвэрлэсэн талбайн хэмжээгээр м2/га (Одоо нийт 450,000 м2) | 5 га | 5 га | Зам талбайн үйлчлэгч нарын ажлыг хөнгөвчлөх, цаг хэмнэх үүднээс техникжүүлэх ажлыг үе шаттайгаар хийж байна. Одоогоор замын шороо тоос цэвэрлэх түрдэг тэрэг-5, хатуураагүй цас цэвэрлэх авто үлээгүүр-2, давс цацах төхөөрөмж-1, цас түрж зайлуулагч-3, цасыг цацаж зайлуулагч-1 буюу нийт 12 техник төхөөрөмжийг ашиглаж байна. Нийт талбайн 10 га газрыг механикжсан техникээр цэвэрлэж байна. Зарим багаж хэрэгслийг өөрсдийн гараар хийж техник хэрэгслийг нэмэгдүүлж ажиллаж байна. Нийт 15,750,000 төгрөгийн төсөв зарцуулсан. | 100 хувь |
| 1.5 | Эко ариун цэврийн байгууламжтай айл өрхийн тоог нэмэгдүүлэх. | ОНХСан 200 сая | Айл өрхийн тоогоор | 295 | 561 /266 нэмэгдэх/ | Аймгийн ОНХСангаас 180 сая, сумын ОНХСангаас 532,8 сая, нийт 712,8 сая төгрөгөөр Эко ариун цэврийн байгууламж бий төсөв тавигдсан. Тус ажлын тендер зарлагдаж 2024 оны 10 сард "Отгон нинж" ХХКомпани шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. ажил нь он дамжиж гүйцэтгэгдэж байгаа нийт 266 нойл хийхээс одоогийн байдлаар 100 айлд эко нойлыг бүрэн хийж гүйцэтгэсэн байна. | 50 хувь |
| 1.6 | Их Монгол, Баяннамсрай, Арвайн хүрээ цэцэрлэгт хүрээлэнгүүдэд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. | ОНХСан 110 сая | тарьж ургуулсан мод бутны тоогоор | | 4000 ширхэг | Энэ онд хавар болон намрын мод тарилтаар "Баяннамсрай" цэцэрлэгт хүрээлэнд шинээр нийт 15193 ширхэг шархайс, гүйлс, улиас, хайлаас зэрэг гоёлын болон навчит мод бут,"Их Монгол" цэцэрлэгт хүрээлэнд Банкуудын холбооны нэрэмжит төгөл байгуулахаар 1,5 га талбайд шинээр 5550 ширхэг монос, далан хайлс, гүйлс, голт бор, гацуур, хайлаас зэрэг гоёлын болон навчит мод бут, нөхөн тарилтаар 800 ширхэг хайлаас тарьсан 21543 мод бутыг шинээр болон нөхөн тарилтаар тарьж байна.Усалгаа арчилгааг тогтмол хийж "Арвайхээр цэцэрлэгжилт" ОНӨААТҮГазар хариуцан ажиллаж байна. Амьдралт 89 хувьтай байна. 2025 онд Их монгол, Баян намсрай цэцэрлэгт хүрээлэнгүүдэд орон нутгийн төсвөөр тог татаж усалгааны асуудлыг 100 хувь шийдсэн. | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | Согоотын 1 дүгээр багийг жишиг ногоон байгууламжтай баг болгох. | | мод, бут тарьсан өрхийн тоогоор | 250 | 300 | Арвайхээр сумын Согоотын 1 дүгээр багийг жишиг ногоон байгууламжтай баг болгох зорилгоор Аюулгүй тойргын ногоон байгууламжидад 158 ширхэг хайлаас тарьж ургуулсан. Мөн хашаагаа "Гэр хорооллын стандарт"-ын дагуу тохижуулж, мод бут тарьж ногоон орчин бий болгох сонирхолтой ая тухтай амьдрах орчин бүрдүүлсэн жишиг тохижилттой айл өрхүүдтэй хамтран ажиллаж мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажилласан."Арвайхээр цэцэрлэгжилт" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас 200 ширхэг хайлаас 40 айл өрхүүдэд өгч тариулсан. Амьдралт 85 хувьтай байна. | 100 хувь |
| **ХОЁР: ХОТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ДАГУУ ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛЖ, ОРЧНЫ ТОХИЖИЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | | | | | |
| 2.1 | Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, фасадыг үе шаттайгаар засварлах ажлыг зохион байгуулах | ОНТөсөв | Засвар хийсэн орон сууцны тоогоор | 2024 2 фасад 4 орон сууцны дээврийн засвар | 17 | Аймгийн ОНХСангийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр 5 дугаар багийн 205, 219, Онги 13 дугаар багийн 905, Рашаант 8 дугаар багийн 466 дугаар байрнуудын дээвэр, мөн рашаант 8 дугаар багийн 343 дугаар байрны гадна фасадын засварыг "Лорд хаус" ХХКомпани 410 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Иргэдийн аятай тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжрууллаа. | 100 хувь |
| 2.2 | Нэрэмжит гудамж бүрийн агуулга онцлогийг харуулсан зураг боловсруулж цахим орчинд сурталчилан танилцуулах | - | Цахим орчинд нийтэлсэн мэдээллийн тоогоор | - | 20 | Нэрэмжит гудамж бүрийн агуулга онцлогийг харуулсан постер, мэдээлэл бэлдэж байна. | 0 |
| 2.3 | Тухайн жилийн ногоон байгууламжийн ажлын зураглал, ландшафтын төлөвлөлтийг гаргаж, биелэлтэд хяналт тавих. | - | Төлөвлөгөөний биелэлтийн хувиар | 70 | 100 | 2025 онд 4-р багийн ногоон байгууламжийн ажлын зураглал хийж, 2093 ширхэг мод, бутыг тарьж суулгасан. Мөн Зүлэгт 12 дугаар багт 1га талбайн зураг гаргасан байна. | 100 хувь |
| 2.4 | Хатуу хучилттай авто зам, явган болон унадаг дугуйн засвар арчлалт, тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу зохион байгуулах | 256 сая | Засвар үйлчилгээ хийсэн талбайн М2 | 1445м2 | 1500м2 | Арвайхээр сумын нутаг дэвсгэрт нийт 33,400 метр авто замд нөхөөс, засварын ажлыг "Арвайхээр тохижилт үйлчилгээ" ОНӨААТҮГазар гүйцэтгэсэн. Аймгийн худалдан авах газраас 290 сая төгрөгийн санхүүжилт | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олгож, авто замын нөхөөс хийх шаардлагатай тоног төхөөрөмж болон 500тн асфальт худалдан авсан. Санхүүжилтийн үр дүнд сумын авто замын эвдрэл, гэмтлийн нөхөөсний ажил хийгдэж, нийт 3200м2 талбайд ажлыг гүйцэтгэсэн.<br><br>“Хас Гарьд Констракшн” хязгаарлагдмал хариуцлагатай компани Намнансүрэнгийн гудамж А301 авто зам дагуу урд талын авто замын гэрлэн дохионы өргөтгөл, Хас банкны уулзварын гэрлэн дохионы өргөтгөлийг хийж гүйцэтгэсэн. Буга согоотын өндөрлөгөөс 12 дугаар цэцэрлэг хүртэлх 1,2 км авто замын шинэчлэлт, 1 дүгээр багийн тойргоос баруун дөрвөн зам хүртэлх 680 метр авто замын шинэчлэлтийн ажлыг “Хас Гарьд Констракшн” хязгаарлагдмал хариуцлагатай компани 945,608,572 төгрөгийн өртгөөр гүйцэтгэн хүлээлгэж өгсөн. Дэлгэрэх 3 дугаар багийн арын Түгийн овооны 700 метр авто замыг “Дагинас Хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компании 1,3 тэрбум төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Тус ажлуудын зардлыг авто замын сангийн хөрөнгөөс гаргасан. | |
| 2.5 | Хүнс, барааны төв захыг цэгцлэх, төрөлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувиар | - | 60 | Хүнс барааны зах болон томоохон худалдааны төвүүдэд эрсдэлийн үнэлгээ хийж, гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангуулахаар ажлын хэсэг 4 удаа хуралдаж, хурлаас гарсан үүрэг чиглэлийн хүрээнд хариуцсан ажлынхаа хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Төв бараан захыг нүүлгэн шилжүүлэх ажлын хэсгийн 2025.05.16-ны өдрийн хуралдаанаар зах дотор байгууламжийг илүү гаргаж барьсан 19 зөрчил илрүүлж, 05 дугаар сарын 22-ны дотор буулгах албан мэдэгдэл хүргүүлж, 11 зөрчлийг бүрэн арилгуулсан. Мөн ариутгах татуургын улаан шугамыг тавьж, “Онги ус суваг” төрийн болон орон нутгийн өмчийн оролцоот хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ерөнхий инженерт хүлээлгэн өгсөн. Ерөнхий боловсролын 1 дүгээр | 40 хувь |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн зүүн тал “Голден пэн” үйлчилгээний төвийн хойд хэсгийн газрыг чөлөөлж, сургуулийн хүүхдүүд нэвтрэх гарц гаргах ажил явагдаж байна. Орхон супермаркетын хойно авто зам хөндлөн гарах явган хүний зам, төмөр гүүрэн гарц гаргаж, тэмдэг тэмдэглэгээ хийсэн. Захын баруун урд талын хашаалсан талбайд овоолго үүсгэсэн 2000м2 талбайг тэгшилж, чөлөөлөх ажил хийгдэж, авто зогсоол байгуулах боломж бүрдэж байна. Төв захын хойд хэсэг буюу 15 дугаар цэцэрлэгийн орчимд үйл ажиллагаа явуулдаг 1 иргэний нийтийн эзэмшлийн талбай хашаалсан зөрчлийг арилгуулж, газар чөлөөлүүлсэн. Шунхлай худалдааны төвөөс ирсэн албан бичгийн дагуу газар дээр нь ажиллан заавар зөвлөгөө өгч, 110 машины зогсоол, цагаан зураас, худалдаалах талбайн тэмдэг тэмдэглэгээ хийлгэж, хяналтын камер, харуул хамгаалалтын байдалтай танилцаж, бэлэн байдлыг хангуулсан. 2025.05.19-ний өдөр зах тойрсон машины худалдаа эрхлэгч 8 иргэнийг дуудан хуралдаж, нийтийн эзэмшлийн зам талбай чөлөөлж, Шунхлай худалдааны төвийн гадна талбай, Орд техникийн захын гадна талбай зэрэг заасан цэгт худалдаа эрхлэхийг даалгасан. Түүхий эдийн захыг нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд 12 дугаар багт байрлах мал, мал амьтны гаралтай түүхий эдийн төвлөрсөн цэгт газрын даамалтай хамтран 1га газарт хэмжилт хийж байршлыг тогтоож хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ хийх үүрэг чиглэл өгсөн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | Арвайхээр хотын камержуулалтыг нэмэгдүүлж, засвар шинэчлэл хийх ажлыг зохион байгуулах. | ОНХСан 207.789.1 мян төг | Засвар үйлчилгээ хийсэн тоогоор | 21ш камер | 10 | Арвайхээр сумын төвийн нутаг дэвсгэр нийт 207 ширхэг камер төрийн үйлчилгээ мэдээллийн төвд хянагдаж байна. 50 ширхэг камер ашиглалтын хугацаа дууссан, 157 камер хэвийн ажиллаж байна. Үүнээс чиглэлийн камер 136 ширхэг, 20 ширхэг 360 камер, 1 ширхэг дугаар таних камер байна. Энэ онд Арвайхээр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр камер нэмэгдүүлэх тендер зарлагдсан боловч, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбогдуулан санхүүжилт татагдсан. “Ухаалаг ногоон бүс” төслийн хүрээнд, сумын Засаг дарга, цагдаагийн газрын дарга хамтарсан “Аж ахуйн нэгж, гудамж талбайн камерын хяналтыг сайжруулах” ажлын төлөвлөгөө гарган хяналт шалгалт хийж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулж буй 182 байгууллага, 6 сургууль, 15 цэцэрлэгт, 3 өрхийн эмнэлэгийн нийт 827 камер байдаг бөгөөд албан байгуулга аж ахуйн нэгж өөрсдийн хөрөнгөөр 175 камерыг шинэчлэн суурилуулж, 63 камерыг засварлаж камерын шинэчлэлд нийт 54,9 сая төгрөг зарцуулсан байна. | 100 хувь |
| 2.7 | “Арвайн хүрээ” цэцэрлэгт хүрээлэнд тохижилтын ажил хийх зохион байгуулах | ОНТөсөв 121 сая | Төлөвлөгөөний хувиар | 70 | 100 | Энэ онд Арвайхээр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Арвайн хүрээ” цэцэрлэгт хүрээлэнд тохижилтын ажлын тендер зарлагдсан боловч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2025 онд хэрэгжих боломжгүй болсон. | 50 хувь |
| 2.8 | Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих. | ОНХСан 22.959.2 сая | Засвар үйлчилгээ хийсэн тоглоомын талбайн тоогоор | 4 | 6 | Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээний ажлыг “Мандах Тэгс Гурван эрдэнэ” ХХКомпани гүйцэтгэсэн. Ажлын хүрээнд 1-р баг, 2-р баг, 4-р баг, 10-р баг ,11-р баг, 5-р багуудын тоглоомын талбайн засвар үйлчилгээг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна. | 100 хувь |
| 2.9 | Гэр хороололд худаг усан сан барих, цахимжуулах ажлын зохион байгуулах | ОНТөсөв 258 сая | Нэмэгдсэн тоогоор | 44 | 49 | Баялаг говь ХХК шалгарч гэрээ байгуулсан. 2, 4, 7, 11, 12 дугаар багуудад хэрэгжсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувь | 100 хувь |
| 2.10 | Нийтийн эзэмшлийн талбайд 3*3 сагсан бөмбөгийн талбай | ОНХСан | Нэмэгдсэн тоогоор | 4 | 8 | Жаргалан хүлэмж ХХК шалгарч гэрээ байгуулсан. 6, 11, 12, 13 дугаар багуудад хэрэгжсэн. Ажлын гүйцэтгэл | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бий болгох. | 220 сая | | | | 100 хувь | |
| 2.11 | Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн сав, сандалны тоог нэмэгдүүлнэ. | ОНХСан 185 сая | Нэмэгдсэн тоогоор | 95 | 145 ш | Оджи од ХХК шалгарч гэрээ байгуулсан. Нийтийн эзэмшлийн зам талбайд 150 ширхэг хогийн сав, 150 сандал байрлуулсан. Ажлын гүйцэтгэл 100 хувь | 100 хувь |
| **ГУРАВ: ИРГЭДИЙН ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХОТЫН СОЁЛЫН ТАЛААР СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААГ ЦАХИМААР ЯВУУЛЖ, ОНХСАНГИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ.** | | | | | | | |
| 3.1 | Жишиг тохижилттой айл өрхүүдийг цахим орчинд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны тоогоор | 3 удаа | 5 удаа | Өөрийн амьдарч буй орчныг тохижуулан, тав тухтай, цэвэр цэмцгэр орчин бүрдүүлж, хотын соёлыг түгээж, бусдад үлгэр дуурайлал, эерэг нөлөөллийг үзүүлж байгаа 7, 10, 13 дугаар багийн 6 өрхийг оролцуулсан контентыг Соёмбо онлайн телевизтэй хамтран бэлтгэж, олон нийтэд сурталчлан ажилласан. Дээрх контентуудыг 124,0 мянган хүн үзэж сонирхсон байна. | 100 хувь |
| 3.2 | Хотын дүрмийг шинэчлэн боловсруулж, Хотын соёл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувиар | 50 | 100 | 2014 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 6/03 дугаар тоотоор батлагдсан хотын дүрэм хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. 2025 онд хотын дүрмийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд 9 бүлэг, 55 заалттай дүрэм боловсруулан, сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 5 дугаар хурлаар хэлэлцсэн болович дүрмийг боловсруулах, батлуулахад хууль, эрх зүйн орчин дутагдалтай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хүлээгдэж байна. | 100 хувь |
| 3.3 | Орон нутгийн хөгжлийн сангийн санал авах, эрэмбэлэх | - | Санал өгсөн иргэний тоогоор Журмын дагуу | Цахим 253 Цаасан 2100 | Цахим 200 Цаасан 1500 Эрэмбэлэх ажлын хэсгийг байгуулсан байх | Цахим систем, ОНХС гар утасны апплейкнээр хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулсан 11 төсөл арга хэмжээний саналд: цахим 1325 санал цаасаар 2000 гаруй санал авсан байна. Сумын Засаг даргын А/59 дүгээр захирамжаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлэх 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Багийн иргэдийн нийтийн хурлаар эрэмбэлж ирүүлсэн саналыг ажлын хэсэг зохих журмын дагуу эрэмбэлж сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8, малын тоо толгойн албан татварын орлогоор 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргад хүргүүлж | 100 хувь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Төсөвт өртөг өндөр сумын төсөв, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийгдэх боломжгүй 5 төсөл арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэн ажилласан. | |
| 3.4 | Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих. | - | Цахим системд нийтэлсэн байдлаар | 39 | 18 | Худалдан авах төлөвлөгөөний дагуу tender.gov.mn цахим системээр 21, шууд худалдан авалтаар 9 тендерийг зохион байгуулснаас 30 тендер үр дүн гарч гэрээ байгуулах эрх олгож ажлын гүйцэтгэл 100 хувь хэрэгжин ажил хүлээж авах комисс ажилласан байна. 2 тендер хэмнэлтийн хуулиар 2025 онд хэрэгжих боломжгүй, 3 тендер төсөвт өртөг хүрэлцээгүй улмаас хэрэгжих боломжгүй болсон, 3 тендер хэрэгжих байна. Нийт 37 тендерийн үр дүнг нийтлэн оруулсан байна. Үнэлгээний хороо тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийн бүрдлийг тухай бүрт нь хийн ажилласан байна. | 90 хувь |
| 3.5 | Өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгох экскурс аялал зохион байгуулах. | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоогоор | 4 удаа | 6 удаа | Төрийн албан хаагчид болон өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгох зорилгоор 2025 онд “Мод тарихын ач тус “Мод тарих аргачлал сэдэвт 8 удаагийн сургалтыг Өвөрхангай аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж ажилласан.Үүнд:<br>• Зэвсэгт хүчний 256-р ангийн 115 алба хаагч<br>• Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын 76 алба хаагч<br>• Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын 54 албан хаагч<br>• Өвөрхангай аймгийн Цагдаагийн газрын 98 албан хаагч<br>• Өвөрхангай аймгийн Ус цаг уур орчин шинжилгээний газрын 34 албан хаагч<br>• Арвай хээр сумын ерөнхий боловсролын нэг дүгээр сургуулийн 78 багш, ажилчид<br>• Тэмүүлэл-Эрдэм сургуулийн 63 багш, ажилчдад танхимын сургалтыг зохион | 100 хувь |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллаа.<br>2025 онд танхимын сургалт 7, практик сургалт 1 нийт 8 удаагын сургалтанд 455 төрийн албан хаагчид, 80 сурагч хамрагдлаа.<br>Мөн Монгол Солонгосын хамтарсан "Ногоон хэрэм" төслийн менежертэй хамтран эко аялал,мод тарих арга технологи сэдэвт практик сургалтыг "Тэмүүлэл – Эрдэм" сургуулийн ахлах ангийн 80 сурагчдад зааж зохион байгуулж ажилласан.<br>Төлөвлөсөн үр дүнд хүрсэн-100 хувь | |

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР Б.ЗОЛБОО

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЭНХМАА

**2025.11.28**

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

(УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН БУЮУ НЭГЖИЙН ДАРГА)

Байгууллагын нэр: АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
Нэгжийн нэр: ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБА

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| **НЭГ: АЖ АХУЙ НЭГЖ, ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙГООР ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЗАМААР ЭРҮҮЛ ЦЭВЭР ОРЧИН БҮРДҮҮЛНЭ.** | | | |
| 1 | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг 10, 11, 13 дугаар багаас эхлүүлж, тус багуудийн айл өрхийн 30 хувьд хүргэнэ. | 34 | 30,4 |
| 2 | Хог хаягдлыг багасгах зорилгоор хоёрдогч түүхий эд авах цэгийг ашиглалтанд оруулж, ангилан ялгах, боловсруулах ажлыг эрчимжүүлэх | 80 | 38 |
| 3 | Түгээ овооны хогийн цэгийн тэлэлтийг багасгах, түрж тэгшлэх ажлыг тогтмол зохион байгуулж, хог шатах эрсдэлээс урьдчилан сэргийлэх. | 100 | 70 |
| 4 | Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээний техник, хэрэгсэлд засвар үйлчилгээ, шинэчлэл хийхэд зөвлөмж өгч, холбон зуучлах. | 100 | 70 |
| 5 | Эко ариун цэврийн байгууламжтай айл өрхийн тоог нэмэгдүүлэх. | 50 | 40 |
| 6 | Их Монгол, Баяннамсрай, Арвайн хүрээ цэцэрлэгт хүрээлэнгүүдэд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. | 100 | 70 |
| 7 | Согоотын 1 дүгээр багийг жишиг ногоон байгууламжтай баг болгох. | 100 | 70 |
| **ХОЁР: ХОТЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ДАГУУ ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛЖ, ОРЧНЫ ТОХИЖИЛТЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.** | | | |
| 1. | Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, фасадыг үе шаттайгаар засварлах ажлыг зохион байгуулах | 100 | 70 |
| 2 | Нэрэмжит гудамж бүрийн агуулга онцлогийг харуулсан зураг боловсруулж цахим орчинд сурталчилан танилцуулах | 0 | 0 |
| 3 | Тухайн жилийн ногоон байгууламжийн ажлын зураглал, ландшафтын төлөвлөлтийг гаргаж, биелэлтэд хяналт тавих. | 100 | 70 |
| 4 | Хатуу хучилттай авто зам, явган болон унадаг дугуйн засвар арчлалт, | 100 | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу зохион байгуулах | | |
| 5 | Хүнс, барааны төв захыг цэгцлэх, төрөлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | 40 | 34 |
| 6 | Арвайхээр хотын камержуулалтыг нэмэгдүүлж, засвар шинэчлэл хийх ажлыг зохион байгуулах. | 100 | 70 |
| 7 | “Арвайн хүрээ” цэцэрлэгт хүрээлэнд тохижилтын ажил хийх зохион байгуулах | 50 | 40 |
| 8 | Гэр хороололд хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих. | 100 | 70 |
| 9 | Гэр хороололд худаг усан сан барих, цахимжуулах ажлын зохион байгуулах | 100 | 70 |
| 10 | Нийтийн эзэмшлийн талбайд 3*3 сагсан бөмбөгийн талбай бий болгох. | 100 | 70 |
| 11 | Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн сав, сандалны тоог нэмэгдүүлнэ. | 100 | 70 |
| **ГУРАВ: ИРГЭДИЙН ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ХОТЫН СОЁЛЫН ТАЛААР СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААГ ЦАХИМААР ЯВУУЛЖ, ОНХСАНГИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ.** | | | |
| 1 | Жишиг тохижилттой айл өрхүүдийг цахим орчинд таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулах | 100 | 70 |
| 2 | Хотын дүрмийг шинэчлэн боловсруулж, Хотын соёл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ. | 100 | 70 |
| 3 | Орон нутгийн хөгжлийн сангийн санал авах, эрэмбэлэх | 100 | 70 |
| 4 | Худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлд хяналт тавих. | 90 | 64 |
| 5 | Өсвөр үеийнхэнд экологийн боловсрол олгох экскурс аялал зохион байгуулах. | 100 | 70 |
| **Дундаж оноо** | | | 60 |

2. **Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Үндэсний бичгийн мэдлэгээ дээшлүүлэх, сургалтад хамрагдах | 100 | 15 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорил, арга хэмжээний дундаж оноо** | | | 15 |

3. **Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн |
|---|---|---|

| | | үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 15 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 10 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 10 |
| 4. | Манлайлах | 15 |
| 5. | Багаар ажиллах | 15 |
| 6. | Харилцаа | 15 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | |

4. **Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 70 хүртлэх оноо<br>60 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 15 хүртлэх оноо<br>15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)* | 15 хүртлэх оноо<br>13,3 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих )* | 88,3 оноо |
| Нийт оноо=<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+ Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх арга хэмжээний оноо+ Хандлага, ёс зүйн, ур чадварын оноо)-Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтын дагуу хассан оноо | | 88,3. |

***Үнэлгээг өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ........................ /С.ГАНЧИМЭГ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.08 *(огноо)*

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ ДАРГА ........................ /Б.ЗОЛБОО/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2025.11.28. *(огноо)*